



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гаалийн ерөнхий газрын Замын-Үүд дэх Гаалийн газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/137/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: Ч.Хэрлэнчимэг Утас: 70523020 Цахим хаяг: Kherlenchimegch@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	153.5	195.2
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	26,870.5	24,529.5
	Нийт хөрөнгийн дүн	27,024.0	24,724.7
	Нийт өр төлбөрийн дүн		
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	27,024.0	24,724.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	27,024.0	24,724.7
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,537.5	5,662.4
	Үйл ажиллагааны зардлын дүн	7,529.0	7,976.6
	Үйл ажиллагааны үр дүн	(1,991.5)	(2,314.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн		(0.1)
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(1,991.5)	(2,314.3)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	29,015.5	27,039.0
	Тайлант оны үр дүн	(1,991.5)	(2,314.3)
	Эцсийн үлдэгдэл	27,024.0	24,724.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,494.3	4,836.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	4,494.3	4,836.8
	Үйл ажиллагааны ЦМГ	-	-
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	-
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	4,308.4	4,331.4
	Урсгал зардал	4,308.4	4,331.4
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	4,471.4	4,820.8
	Улсын төсвөөс санхүүжих	4,464.2	4,814.1
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	7.2	6.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

ГЕГ-ын Замын-Үүд дэх Гаалийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Гаалийн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих,
- Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэл, түүний хөдөлгөөнд хяналт тавих.
- Татвар төлөгчөөс хураан авсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлэх.

Гаалийн байгууллага нь эрхэм зорилгоо “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэх” гэж тодорхойлсон байна.

Дээрх зорилгын хүрээнд дараах 4 стратеги зорилгыг тодорхойлсон байна. Үүнд:

1. Олон Улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, аюулгүй байдлыг хангах,
2. Бараа, тээврийн хэрэгслийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхтэй тэмцэх,
3. Улсын төсвийн орлогыг шударга, үр ашигтай, үр дүнтэй бүрдүүлэх,
4. Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхийг бэхжүүлэх

Гаалийн байгууллага нь 2021 онд “Мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бэхжүүлэх замаар үндэсний аюулгүй байдлыг хангаж, эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих” зорилгыг дэвшүүлсэн байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мэргэжлийн хяналтын байгууллагын улсын хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт шалгалт хийх чиг үүргийг гаалийн байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 4-ний өдрийн тогтоолоор мэргэжлийн хяналтын байгууллагын албан хаагчид, эд хөрөнгө, байр зэргийг гаалийн байгууллагад шилжүүлж, бүтцийг өөрчлөн батлахаар тусгасан байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Өмнөх онд тус байгууллага нь офисын барилга худалдаж авсан ба уг барилгын засвар болон тохижилтын ажилд, мөн албан хаагчдын оршин суудаг албаны байрны сантехникийн засварын ажилд урсгал засварын зардалд нийт 109.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Өмнөх онуудад болон тайлант оны 4 дүгээр сар хүртэл “Соёмбо” хотхоны 70 айлын орон сууцны 2 объектыг тус байгууллага нь дулаанаар хангаж, орлого бүрдүүлж ажилладаг байсан. Тайлант 2021 оны 10 дугаар сараас Замын-Үүд суманд шинэ дулааны станц ашиглалтад орж, дээрх айл өрхийг дулаанаар хангаж эхэлсэнтэй холбоотойгоор гаалийн газар нь дулаанаар хангах туслах үйл ажиллагааг зогсоосон байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 4,829.3 сая төгрөгийн 17 орлогын гүйлгээ, 340.9 сая төгрөгийн 37 зарлагын гүйлгээ, 318.7 сая төгрөгийн 35 худалдан авах ажиллагаа, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 33 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулгаж, шалгахад нийт 5 мэдээллийн хугацааг хоцроож байршуулсан байна. Үүнд, 4 дүгээр сарын 346.2 сая төгрөгийн санхүүжилт, 1, 2, 4 дүгээр саруудын цалингийн нэмэгдэл олгох тушаалуудыг 4 дүгээр сард хугацаа хоцроож байршуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, худалдан авах ажиллагааны мэдээллийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллага нь 2022 онд Хилийн мэргэжлийн хяналтын газартай нэгдэж байгаатай холбоотойгоор нэгтгэсэн санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд чиглэсэн аудитын нэмэлт горимыг гүйцэтгэх нь зүйтэй.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 12.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.9 сая төгрөгийн алдааг залруулж, 9.5 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад зардлын ангиллыг буруу тусгасан гүйлгээг залруулсан ба дараах 3 зөвлөмжийг өгсөн. Үүнд:

- Барилга байгууламж, орон сууц дансанд 107.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 2011 онд бүртгэсэн “Орон сууцны завсар” нэртэй 1 хөрөнгө бүртгэлтэй байгаа хөрөнгийн нэрийг тодорхой болгож, бүртгэлд тусгах.
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 67 нэр төрлийн 3,354.9 сая төгрөгийн 123 ширхэг бүртгэлтэй байгааг дахин үнэлгээ тогтоох, актлах замаар шийдвэрлэх.
- Машин тоног төхөөрөмж дансанд цахилгаан халаалтын нэг бүр нь 7.8 сая төгрөгийн 2 ширхэг тогооны элэгдлийг 9.4 сая төгрөгөөр дутуу тооцсон байгааг анхан шатны баримтад үндэслэн нөхөн тооцож, бүртгэх.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	4	12.4	1	2.9	-	-	-	-	3	9.5
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	4	12.4	1	2.9	-	-	-	-	3	9.5